



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

“УЛААНБААТАРЫН ӨВЛИЙН НААДАМ  
2018” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, НИТХ-ын 2017 оны 01/19 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.9, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.5, 1.4.6, 1.4.9 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/42 тоот захирамж, Газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам 2018” арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 03,04-ний өдөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Б.Тулгаа/-т үүрэг болгосугай.

2. “Улаанбаатарын өвлийн наадам 2018” арга хэмжээг зохион байгуулах ажилд шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. “Улаанбаатарын өвлийн наадам 2018” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 55 846 500 /тавин таван сая найман зуун дөчин зургаан мянга таван зуун/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batbayar* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 01 сарын 19 өдрийн А.С.Эдугаар тушаалын хавсралт

1117139265  
УОА0453 5284325

“УЛААНБААТАРЫН ӨВЛИЙН НААДАМ 2018” АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2018.01.19

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
<b>Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр</b>				
1	Тайзны анонс хэвлүүлэх	8м*4м	12500	400 000
2	Тайзны хормойн анонс	8м*2м	10 000	160 000
3	Нугалбар /ерөнхий мэдээлэл/	A4 6000ш	500	3 000 000
4	Анонс ҮЦХ-н самбарт слайд хэвлүүлэх /110:210 см/	2ш	20 000	40 000
	Гэр, асарын анонс /тогтоогчийн хамт/	10ш	20 000	200 000
5	Шатрын хөлөг /анонс хэвлэлт/	6.4*6.4	10 000	409600
6	Мөсөнд авиралтын сургалтын анонс	10ш	7920	79200
7	Хэвлэлийн дизайны эх бэлтгэл, сурталчилгааны шторк хийлгэх	20 сек	1 500 000	1 500 000
8	ТВ Форматад оруулан, нэвтрүүлэг бэлтгүүлэх	багц	2 000 000	2 000 000
9	Сурталчилгааны хуудас хэвлүүлэх	1000ш	1400	1 400 000
10	Гадаад оролцогчдын зочид буудлын зардал	2 ортой стандарт өрөө 9 ш* 3 өдөр	105600	2 851 200
		1 ортой стандарт өрөө 2 ш* 3 өдөр	93600	561 600
	Хоолны зардал	20 хүн /өдөрт 2 удаа 3 өдөр хооллох/	30 000	3 600 000
11	Гадаадын зочид, урлагынхны автобусны түрээс	4 өдөр* 3ш	125 000	750 000
<b>Дүн</b>				<b>16 951 600</b>
<b>Зохион байгуулалтын чиглэлээр</b>				
12	Мөсөн сурын зохион байгуулалт, тэмцээний урамшуулал	Тэмцээний урамшуулал	1-р байр 300 000	900 000
			2-р байр 200 000	
			3-р байр 100 000	
		Зохион байгуулалт+ сонирхогч тэмцээн	300 000	
13	Мөсөн шагай	10 хүн	100 000	1 000 000



14	Рагби+ зохион байгуулалтын зардал	багц	1 244 000	1 244 000
15	Хөтлөгчийн хөлс	багц	1 600 000	1 600 000
16	Хоолны том тогоо тээвэрлэх зардал /Хэмжээ 3,5 м/	2 удаа	150 000	300 000
17	Ачааны машин түрээслэх зардал	2 өдөр	150 000	300 000
18	Хөгжим, техник хэрэгсэл, техникийн ажилтан, тайз түрээслэх, чимэглэл	2 өдөр	2 500 000	5 000 000
19	Параглайдингийн үзүүлбэр	Багц /2 өдөр,6 хүн/	1 000 000	1 000 000
20	Нохойтой чарганы тээвэрлэлтийн хөлс	4 удаа	150 000	600 000
21	Тэшүүрийн тоглолт	16 хүн* 2 өдөр	25 000	800 000
22	Ууланд авиралтын сургалт зохион байгуулах	багц	300 000	300 000
23	Зохион байгуулагчдын ус, хоол, унааны мөнгө	45 хүн* 2 өдөр	10 000	900 000
24	Шагнал урамшуулал, шүүгчийн зардал	багц	3 000 000	3 000 000
<b>Дүн</b>				<b>16 944 000</b>
<b>Талбайн тохижилтын ажил, арга хэмжээ</b>				
25	Мөсөн хана бэлтгэх	багц	3 000 000	3 000 000
26	Снөүбоардын талбай бэлтгэх, тэмцээн уралдаан зохион байгуулалтын зардал	багц	2 000 000	2 000 000
27	Тэшүүрийн талбай хийх	багц	3 100 000	3 100 000
28	Мөсөн шагайн талбай хийх	багц	4 960 000	4 960 000
29	Цэвэрлэгээ, зөөврийн бие засах газрууд тээвэрлэх, байрлуулах	багц	2 000 000	2 000 000
30	Гэр түрээслэх	5ш	230 180	1 150 900
31	Асар түрээслэх	10ш* 2 өдөр	80 000	1 600 000
32	Хоолны шоу /Адууны махтай цуйван /3,5м2 хайруулын таваг/	багц	2 500 000	2 500 000
33	Тогооч нарын ажиллах хөлс	10 хүн* 1 өдөр	100 000	1 000 000
34	Асар, гэрт цахилгаан татах утас, залгуур авах	багц	200 000	200 000
35	Сандал түрээслэх	50ш*2 өдөр	2000	200 000
36	Ширээ түрээслэх	20ш*2 өдөр	6000	240 000
<b>Дүн</b>				<b>21 950 900</b>
<b>Нийт дүн</b>				<b>55 846 500</b>

--00000--